

# **ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ БА СУУРЬ СУРГУУЛИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА 2019/2020**

## **ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦЭС ХҮРТЭЛ**

(товч агуулга – аав ээж нарт зориулсан ерөнхий мэдээлэл)

Энэ бичиг баримт нь суурь сургуулиудын үндсэн үйл ажиллагааны нөхцлийг зааж өгнө, тэгэхдээ сургуульд 1-р үе шатны сурагчид ба 9-р ангийн сурагчид ирэхийг анхаарна.

Суурь сургуульд сурагчдын хөдөлгөөн нь дараагийн зарчмуудыг баримталдаг:

### **Сургуульд очих ба сургуулиас буцах**

Сургуульд очих ба сургуулиас буцах замд сурагчид нь онцгой байдлын нөхцлийн дагуу тогтоосон ерөнхий дүрмүүдийг баримтлах болно, ялангуяа:

- Ам ба хамраа хамгаалах хэрэгслээр халхлах (цаашдаа зөвхөн „амны хаалт“).
- Хямралын буюу онцгой байдлын нөхцлийн дагуу хүний хоорондох нийгмийн зай 2 метр баримтлах (гэвч, жишээлвэл, сурагчийг дагах хүнд/гэр бүлийн гишүүнд үүнийг баримтлах хэрэггүй).

### **Сургуульд ирэх ба сургуулийн өмнөх хөдөлгөөн**

Сургуулийн өмнө хямралын буюу онцгой байдлын нөхцлийн дагуу нийгмийн зай 2 метр баримтлах (гэвч, жишээлвэл, сурагчийг дагах хүнд/гэр бүлийн гишүүн баримтлах хэрэггүй).

- Сургуулийн өмнө байгаа бүх хүмүүс ам ба хамраа амны хаалтаар хаах хэрэгтэй.
- Сургуулийн өмнө сурагчдыг томилогдсон сурган хүмүүжүүлэх ажилтан хүлээж авдаг, тэгээд сурагчдыг бүлгэм болгож зохицуулаад дагуулж явдаг.

### **Сургуулийн байранд буюу сургуулийн байгууламжинд орох**

- Сургуулийн байранд зөвхөн сурагчид орж болно, дагалдаж явсан хүмүүс орж болохгүй.
- Бүх сурагчид ба сургуулийн ажилтнууд нь нийтлэг зайд амны хаалтыг зүүдэг.
- Сурагч болгон өдөрт хамгийн багаар 2 амны хаалттай байх ёстой бөгөөд үүнийг хадгалах ууттай байна.
- Сургууль нь сурагчдын явж болох орон зайд хязгаарлан зааж өгөх эрхтэй.
- Сурагч нь тогтоосон эрүүл ахуйн дүрмийг сахих үүрэгтэй; хэрвээ дахин давтаж даган мөрдөхгүй бол, сурагчийн хууль ёсны төлөөлөгчийг анхааруулсны дараа, сурагчийг сургуульд оруулахгүйн учир шалтгаан нь байж болно, жишээлвэл, сурагчийг бүлгэмээс буюу бэлтгэлээс хасаж болно.

### **Сургуулийн байшин дотор**

- Сурагчдын бүлгэмийн шилжүүлэлт, хонгил дээрэх хөдөлгөөн, жорлонд орох буюу нийгмийн өрөөнд орохыг зохион байгуулахдаа бүлгэмүүдийн дотор бас хувь хүний ба сургуулийн ажилтнуудын хоронд ч гэсэн хамгийн бага хэмжээгээр уулзалдаж байх журмыг баримтална.
- Шилжүүлж явахдаа хүний хооронд 2 метр нийгмийн зайд баримтлах хэрэгтэй, хэрвээ боломжтой байвал (хамгийн багаар 1,5 метр).
- Боломжийн дагуу завсаргалааны үед гадагшаа гарвал сайн байдаг. Ангиас гарахын өмнө бүх сурагчид ангиас гадуур явах үед амны хаалтыг зүүх ёстой.
- Тогтоосон дүрмийн дагуу цэвэрлэгээ, ариутгал ба бусад эрүүл ахуйн арга хэмжээнүүдийг явуулах болно.

### **Ангийн дотор**

- Сурагч болгон гутлаа авсны дараа, ангидаа орсны дараа гараа ариутгагчаар цэвэрлэнэ. Түүнээс өмнө гараа усаар угаасан байж болно ( 20 - 30 секундын туршид шингэн савангаар сайтар угаана).
- Сурагчдын бүрэлдүүлбэр урьдчилан тогтоодог бөгөөд өөрчлөгддөггүй.
- Нэг бүлгэмд хамгийн ихдээ 15 сурагч байх бөгөөд анги дотор нэг ширээнд нэг сурагч суух зарчмыг баримтлах ёстай.
- Анги дотор байхдаа сурагчид бас багш нар ч гэсэн амны хаалтыг зүүх хэрэггүй, хэрвээ нийгмийн зайд 2 метр баритлагдаж байвал (хамгийн багаар 1,5 метр). Хэрвээ ойрхи холбоотой байх болвол (жишээлвэл, бүлгэмийн ажил хийхэд), ангийн дотор ч гэсэн амны хаалтыг зүүх ёстай.
- Сурагч болгон амны хаалтыг тайлаад уут руу хадгалдаг.
- Сурагчид нь боловсролын нэг хэсэг ажил дуусгасны дараа анги дотор гараа ариутгах буюу гараа угаадаг.
- Сургууль нь сурагчдын ирцийн тухай бүртгэл хийдэг.

#### **COVID-19 өвчиний шинж тэмдгүүд гарах тухай сэжиглэлтэй байхад**

- Хэрвээ хэн нэгэн нь амьсгалын замын халдварын COVID-19 өвчиний шинж тэмдгүүдтэй болж байвал (өндөр халуурах, ханиах, гэнэт амт ба үнэр алдагдах, амьсгалын замын халдварын бусад тэмдэгтэй болвол), сургуульд орж болохгүй.
- Хэрвээ сурагч нь COVID-19 өвчиний ямар нэг шинж тэмдгүүдийг илрүүлж байвал, түүнийг тусгай өрөөнд байлгаад, сурагчийн хууль ёсны төлөөлөгчид мэдээлэл өгөхөд, хүүхдийг тэр даруй сургуулиас авах ёстай болно.

#### **Эрүүл мэндийн яам нь дараах эрсдлийн хүчин зүйл бүхийн жагсаалт тогтоосон:**

1. 65-аас дээш настай архаг өвчтэй холбоотой хүмүүс байж болно.
2. Уушгини архаг өвчин (дунд зэргийн ба хүнд зэргийн гуурсны багтраа өвчин) удаан хугацааны системчилсэн фармакологийн эмчилгээтэй.
3. Зүрхний өвчин буюу цусны том судасны өвчлөл удаан хугацааны системчилсэн фармакологийн эмчилгээтэй, жишээлвэл, цусны даралтын ихсэлт.
4. Дархлааны тогтолцооны эмгэг байдал, жишээлвэл,
  - a) дархлаа дарангүйлэх эмчилгээ (стероидууд, ХДХВ гэх мэт),
  - b) хорт хавдрын эсрэг эмчилгээ,
  - c) чухал эрхтэн буюу ясны чөмөг шилжүүлэн суулгасны дараа
5. Хэтэрхий таргалалттай хүн (биенийн жингийн индексээс  $40 \text{ кг}/\text{м}^2$ ) илүү жинтэй хүн.
6. Фармакологийн аргаар эмчилдэг чихрийн шижин өвчинтэй.
7. Бөөрний архаг өвчтэй, түр зуурын эсвэл удаан хугацааны дэмжлэг шаардагдах/бөөрний үйл ажиллагааг солих (диализ).
8. Элэгний өвчин (анхдагч эсвэл хоёрдагч).

#### **Хэрвээ сурагч энэ эрсдлийн хүчин зүйлтэй бүлгэмд хамарагдах бол юу хийх вэ**

- Хэрвээ сурагч эрсдлийн хүчин зүйлтэй бүлгэмд хамарагдаж байвал, тэдний хууль ёсны төлөөлөгчид нь үүнийг мэдэж ба анхаарч байгаад, сурагчийг боловсролын үйл ажиллагаанд оруулах тухай шийдвэрлэнэ үү гэж зөвлөж байна.
- Хүүхдийг анх удаа сургуульд оруулахын өмнө түүний хууль ёсны төлөөлөгч нь сургуульд орох хаалганы өмнө дараагийн мэдээлэл өгөх болно:
  1. Эрүүл мэндийн яамны тогтоосон эрсдэлийн хүчин зүйлтэй бүлгэмийг тодорхойлсон бичгээр бичсэн мэдээллтэй танилцсан

2. Вируст халдварт өвчний шинж тэмдгүүд нь байхгүй тухай бичгээр бичсэн үнэнч мэдүүлэг (жишээлвэл, халуурах, ханиах, амьсгал давчдах, гэнэт амт ба үнэр алдагдах гэх мэт).
- Хэрвээ хууль ёсны төлөөлөгч нь ийм бичиг баримтанд гарын үсэг зурахгүй бол, сурагч нь сургуульд биечлэн явах боломжгүй болно.
  - Хууль ёсны төлөөлөгч нь сургуульд явах сонирхлын тухай мэдүүлэх үүрэгтэй, 1-р үе шатны хүхэд 2020.5.18-нд хүртэл; 9-р ангийн сурагчид 2020.5.7-нд хүртэл.

### **1-р үе шатны сурагчийн бүлгэмүүд**

- Суурь сургуулиуд нь Эрүүл мэндийн яамны онцгой арга хэмжээний дагуу суурь сургуулийн 1-ээс 5-р хүртэл ангийн сурагчдад зориулж боловсролын үйл ажиллагаа явуулна.
- Нэг бүлгэмд хамгийн ихдээ 15 сурагчид байна. Тогтол биелүүлэх ёстой нөхцлүүд нь: нэг ширээнд нэг сурагч байх ба ширээнүүд нь хоорондоо зйтай.
- Сурагчдыг сургуульд дахин ирэх боломжтой болсноос хойш 2020.6.30-нд хүртэл бүлгэмүүдийн бүрэлдүүлбэр нь өөрчлөгдөхгүй. Сургуулийн захирал нь сурагчдыг бүлгэмд хуваах тухай шийдвэрлэнэ. Хамгийн сүүлд нь 2020.5.25-нд хүртэл сурагчийг сургуулийн бүлгэмд бүртгэж болно, үүнэс хойш болохгүй.
- Өглөөний хичээлийн бус цагийн сургуулийн бүлгэм байхгүй.
- Сургууль нь сурагчдыг бүлгэмд оролцох ирцийн бүртгэл хийдэг. Хэрвээ сурагч нь сургуульд З өдрөөс илүү хугацаанд явахгүй байвал хууль ёсны төлөөлөгчөөс нь ирэхгүйн учир шалгааныг тодруулж, цаашдаа бүлгэмд явах/үгүй тухай нь лавлаж асуудаг. Энэ хичээл таслах явдал нь сурагчийн гэрчилгээнд заагддаг хичээл таслах тухай мэдээлэлд хамарагдахгүй болно.
- Биеийн тамирын хичээл энгийн ёсоор, усан бассейнд орох гэх мэт, одоогийн байдлаар зөвшөөрөгдөхгүй.
- Өдрийн цагт боловсролын үйл ажиллагаа эхлэх ба дуусгах тухай сургуулийн захирал нь шийдвэрлэдэг.

### **Дунд сургуульд орох элсэлтийн шалгалтанд бэлтгэж байгаа сурагчдад зориулсан тусгай мэдээлэл 2020.5.11-ээс эхлэж хүчинтэй**

- 2020.4.30-нд гарсан засгийн газрын 491-р тогтоолын дагуу 5-р сарын 11-ээс эхлэж элсэлтийн шалгалтанд бэлтгэж байгаа 9-р ангийн сурагчид нь суургуульд биечлэн хичээлдээ явж болно.
- Боловсролын үйл ажиллагаа нь зөвхөн 9-р ангийн сурагчдаас бүртгэгдсэн бүлгэмүүд дээр явуулагдах болно. Боломжийн дагуу нэг ангийн сурагчдаас бүлгэмүүдийг байгуулвал сайшаагдана.
- Нэг бүлгэмд хамгийн ихдээ 15 сурагчид байж болно. Дараагийн нөхцлүүд нь тогтол биелүүлэгдэнэ: нэг ширээнд нэг сурагч байх ёстой бөгөөд ширэнүүдийн хооронд зйтай байна.
- Бүлгэмийн бүрэлдүүлбэр үргэлж өөрчлөгддөггүй. Сургуулийн захирал нь сурагчдыг бүлгэм болгож хуваадаг. 2020.5.11-ээс хойш сурагчдыг сургуулийн бүлгэмд хувааж болохгүй.
- Сурагчдын нэг бүлгэмд олон багш нар ээлжлэн зааж болно, хэрвээ энэ нь элсэлтийн шалгалтанд бэлтгэх хэрэгтэй тохиолдолд зөвшөөрөгднө.
- Сургалтын агуулга нь юуны өмнө элсэлтийн шалгалтын хичээлүүд болно, гол зорилго нь элсэлтийн шалгалтын бэлтгэл болно. Сургуулийн захирал нь сургалтын цагийн хуваарь ба зохион байгуулалтыг хариуцаж тогтооно.

Иш татасан: Боловсролын, залуучуудын ба биеийн тамирын яам /МШМТ/, Прага, 2020.4.30, Эрүүл мэнд хамгаалах ба суурь сургуулийн үйл ажиллагаа 2019/2020 хичээлийн жилийн эцэс хүртэл